



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОН





АМЬД ХӨРӨНГӨНИЙ *шинэхэн талх*

SOURDOUGH BREAD

АГУУЛГА

Бүлэг **1** КОМПАНИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Бүлэг **2** БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүлэг **3** ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Бүлэг **4** САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2025 хагас жилийн тайлан



БҮЛЭГ

1

КОМПАНИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА ЗОРИЛГО,
ЗОРИЛТ

КОМПАНИЙН ТУХАЙ

Эрүүл хүнс Таны сонголт уриатай “Талх Чихэр” ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 5 шугам, жигнэмэг, чихрийн шугам бүхий “Томбат” ХХК, бялуу, бэйкери төрлийн нандин бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хотол” бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, өдгөө 41 жилтэйгээ золгожээ. Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Чех, Франц, Герман, Голланд, Испани, Финланд, Австри гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн автомат тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа анх удаа нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байна.

- **Оноосон нэр:** “Талх Чихэр” ХК
- **Хэлбэр:** Нээлттэй хувьцаат компани
- **Регистрийн дугаар:** 2074575
- **Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:** Монголын хөрөнгийн бирж
- **МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:** I
- **Гаргасан нийт хувьцааны тоо, ширхэг:**
1,023,703 ширхэг
- **Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:** Хүнсний үйлдвэрлэл, худалдаа

АЛСЫН ХАРАА & ЭРХЭМ ЗОРИЛГО



УРИА ҮГ:

Эрүүл хүнс, таны сонголт



АЛСЫН ХАРАА:

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүний хөгжил, менежментийн бодлогоор тэргүүлэгч, хүнсний салбарын загвар компани байна

Т - Тэргүүн технологи

А - Аюулгүй бүтээгдэхүүн

Ч - Чадварлаг ажилтан

И - Итгэлцэл, түншлэл



БИДНИЙ ОНЦЛОГ



*МҮХАҮТ-ийн GOLD
гишүүн байгууллага.*



*Монголын хүнсчдийн
холбооны гишүүн
байгууллага.*



Хэрэглэгчийн гарт өдөр бүр шинэ бүтээгдэхүүн хүргэх түгээлтийн 100 гаруй машинаар Улаанбаатар хотын 9 дүүрэгт 3500 гаруй харилцагч дэлгүүрт өглөө бүр шинэ бүтээгдэхүүн хүргэж байна.



Талх, талхан бүтээгдэхүүний зах зээлийн 60%-ийг нарийн боовны зах зээлийн 25%-ийг эзэлдэг.



Гурилан бүтээгдэхүүний зах зээлд тэргүүлэгч. Олон улсын стандартуудаар баталгаажсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч



24 цагийн тасралтгүй үйлдвэрлэл. Бүтээгдэхүүн, Техник тоног төхөөрөмжийн шинэчлэлээр салбартаа түйчээлэгч.

1. 24 цагийн тасралтгүй үйлдвэрлэл

2. Хэрэглэгчийн гарт өдөр бүр шинэ бүтээгдэхүүн хүргэх

Тасралтгүй үйл ажиллагаа

1. Стандартаар баталгаажсан бүтээгдэхүүн

Олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн



2. Савлагааны битүүмжлэл, тээвэрлэлтийн аюулгүй байдал

3. Хэрэглээнд нийцсэн, эрүүл, аюулгүй бүтээгдэхүүн

4. Чанартай түүхий эд

5. Тэргүүлэх, амт чанар

1. Хэрэглэхэд хялбар байдал.

2. Борлуулалтын сувгийн хүртээмжтэй байдал

Хэрэгцээнд тулгуурласан сайжруулалт

3. Дотоодын зах зээлд анхлан нутагшуулсан олон улсын бүтээгдэхүүнүүд /Багет, Чиабатта/

4. Уламжлалт бүтээгдэхүүнийг техник технологитой хослуулан үйлдвэрлэх /Хэвийн боов, бялуу/

5. Бүтээгдэхүүнийг хэрэглээндээ тохируулан сонгох боломжтой нэр төрөл олон.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал



БҮЛЭГ

2

**БИЗНЕСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА**



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

/ ЧАНАРЫН ЗОРИЛТ/

1. FSSC 22000 –Хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.
2. Ажилтнуудын сэтгэл зүй болон эрүүл мэндийг дэмжин, тогтвортой, аюулгүй ажиллах нөхцлийг сайжруулж, эвсэг нэгдмэл хамт олон бүрдүүлэх арга хэмжээг сар тутамд явуулах, үндсэн цалин 30%-иар нэмэгдүүлнэ.
3. Талхны үйлдвэрийн хөрөнгө бэлтгэх хэсэгт тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр амьд хөрөнгийн артизан талх үйлдвэрлэж, шугамын хүчин чадлыг 8%-иар нэмэгдүүлэн, шинэ хэрэглээг хөгжүүлнэ.
4. Нарийн боов, бялууны үйлдвэрийн “Юнилайн” шугамд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр технологи ажиллагаа, бүтээгдэхүүний чанар сайжирч бүтээмжийг 6%-иар нэмэгдүүлж хөдөлмөрийг хөнгөвчлөнө.
5. Харилцагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ нэр төрлийг хөгжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэн, зах зээлд өрсөлдөх чадварыг 10%-иар нэмэгдүүлнэ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Гурилан бүтээгдэхүүн хэрэглэгчдийн судалгаа болон улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй талхны хэмжээ, борлуулалтын тоо зэргийг харьцуулж үзэхэд “Талх Чихэр” ХК нь талх, талхан бүтээгдэхүүний зах зээлийн **60%**-ийг дангаараа эзэлж, энэхүү зах зээлийг тэргүүлж байна.

Талх

60%



Нарийн боов

25%

Улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй нарийн боовны хэмжээ, компанийн борлуулалтын тоо зэргийг харьцуулж үзэхэд “Талх Чихэр” ХК нь нарийн боовны зах зээлийн **25%**-ийг эзэлж, ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэй өрсөлдөх зах зээлд томоохон байр суурь эзэлж буй компаниудаас 2т эрэмбэлэгдэж байгаа юм.

Нандин бүтээгдэхүүний зах зээлд ХОТОЛ БЯЛУУ, БЭЙКЕРИ БҮТЭЭГДЭХҮҮН НЬ нэвтрэлтийн шатандаа явж байгаа бөгөөд зөвхөн онцлох баяраар үйлдвэрлэж ирсэн тус бүтээгдэхүүнд бид онцгой ач холбогдол өгч, маркетинг идэвхжүүлэлтийн ажлыг хийж, брэнд болгон хөгжүүлж ирсэн. үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхийн тулд бид хичээн ажиллаж байна.

Бялуу



2025 хагас жилийн тайлан

ЗАХ ЗЭЭЛ ҮЗҮҮЛЭЛТ

B2B зах зээлд энэ жилд харилцагч байгууллагууд нэмж нийт 15 байгууллагад 20 нэр төрлийн талх, талхан бүтээгдэхүүнийг нийлүүлэн ажиллаж байна. Байгууллага бүрийн онцлогт тохирсон бүтээгдэхүүний туршилт тохируулгыг хийж, брэндийн илтгэх сав баглаа боодол дээр ажиллаж амжилттай үйлдвэрлэж нийлүүлсэн.



ҮЙЛДВЭРЛЭЛ

Талх үйлдвэрлэлийн хөрөнгө бэлтгэх тоног төхөөрөмж, Нарийн боов үйлдвэрлэлийн пийшин шинэчлэж, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Чех” улсын J4 компанитай хамтран гэрээ хэлэлцээр хийгдэж баталгаажсан.



МАРКЕТИНГ ИДЭВХЖҮҮЛЭЛТ

Жил бүрийн цагаан сарын баярыг утгаж хэвийн боовны үйлдвэрлэлийн нээлтээ хийдэг уламжлалтай. 2025 оны туулай жилдээ “Аривжих ерөөлтэй цагаан сар” концепцийн хүрээнд цагаан сарын хэвийн боовны борлуулалт идэвхжүүлэлтийн ажил хийсэн.

Идэвхжүүлэлтийн сувгууд:

- Уламжлалт
- Сошиал
- Эвент гэсэн сувгуудаар амжилттай хийж гүйцэтгэсэн.

Хэрэглээний чиг хандлага хувьсан өөрчлөгдөж байгаатай холбогдуулан олон хүн идэх том бялуунаас илүү амт чанартай жижиг бялууг хэрэглэгч илүү сонирхох болсон байна.

Иймээс “Таны аз жаргалын гэрч” уриатай “Хотол” бялууны үйлдвэр хэрэглэгчийн сонирхолд нийцсэн жижиг хэмжээтэй бялууг зах зээлд нийлүүлж, онцлох баяруудаар төлөвлөгөөт маркетингийн идэвхжүүлэлтийг хийснээр өнөөдөр үнэнч хэрэглэгчээ олж эхлээд байна.


Шинэ бүтээгдэхүүн

АТАР
ХЭВИЙН БООВ

ТҮМЭН НАСАН
ХӨВЖИХ БООВ

ӨВ СОЁЛ

ДЯЗГУУР
ЭНЭД ОРШИГУЙН ДАРХЛАА



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС 1984 ОНООС ТАНЫ СОНГОЛТ



2025 хагас жилийн тайлан



БҮЛЭГ 3

ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



33% Дээд боловсролтой



18% Тусгай дунд боловсролтой



46% Бүрэн дунд боловсролтой



3% Бүрэн бус дунд боловсролтой



25% 0-1 жил ажилласан



33% 1-3 жил ажилласан



18% 4-8 жил ажилласан




13% 9-15 жил ажилласан



11% 16-с дээш жил ажилласан

Ажилтнуудын дундаж нас 78,5 %



Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан 32

Нийт ажилтан



940



Эмэгтэй

49,8%



Эрэгтэй

51,3%



Үйлдвэрийн ажилтан 42,6%



Оффис болон бусад ажилтан 57,4%

2025 хагас жилийн тайлан

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, ажлын байрны таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол хийж хэрэгжүүлдэг. Онцолбол:

- ✓ Сэтгэл зүйчийн, сэтгэл заслын сургалт
- ✓ Үйлдвэрийн эмч болон ХАБ инженерийн сургалт
- ✓ Гадаад мэргэжилтэн болон зөвлөх инженерийн технологи болон тоног төхөөрөмжийн сургалт
- ✓ Шинэ ажилтны танилцуулах сургалт
- ✓ Бусад сургалт



Оффисын болон үйлдвэрийн дундаас дээш түвшний ажилтнуудад ажлын үнэмлэх, лого бүхий хувцас олгож эхэлсэн. Ажилтан бүрийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд цалин, урамшуулал нэмэгдүүлсэн.

- ✓ Тусгай ангиллын нэмэгдэл / жолооч нарт /
- ✓ Мэргэшлийн зэргийн нэмэгдэл
- ✓ Тогтвортой ажилласан жилийн нэмэгдэл
- ✓ Гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал
- ✓ Хөдөлмөрийн аварга ажилтаны урамшуулал

Ажилтан бүрийг тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдүүлэх үүднээс спортын тэмцээн, урлагийн наадам, аялал, ур чадварын тэмцээн, шагнал урамшуулал зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- 2006 оноос хойш тогтмол зохион байгуулж байгаа “Агар” хэвийн боовны нэрэмжит аймаг цэргийн цолтой 256 бөхийн 19 дахь удаагаа зохион байгуулж, энэ удаагийн хүчит бөхийн барилдаанд Сүхбаатар аймгийн Онгон сумын харьяат аймгийн хурц арслан Нямдоржийн Өсөхбаяр түрүүлж, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын харьяат аймгийн хурц арслан Даваасүрэнгийн Алтанцоож үзүүрлэсэн.
- Монгол Улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан Хөдөлмөрийн баатруудыг хүндэтгэн алдаршуулдаг "Сайн байцгаана уу? Баатрууд аа" уламжлалт уулзалтыг зохион байгууллаа.
- Амтлаг аялал хөтөлбөрт хамрагдаж, өдөр тутамдаа иддэг бүтээгдэхүүнийхээ хэрхэн үйлдвэрлэгддэгийг өөрсдийн нүдээр харж, нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлдэг. Хөтөлбөр маань хүүхдүүдэд хөдөлмөрийн үнэ цэн, хүнсний эрүүл ахуй, зөв зохистой хэрэглээг таниулдаг давуу талтай билээ. Нийт 32 сургууль, цэцэрлэгийн 1000 гаруй хүүхэд хамрагдсан.
- Сар шинийн баярыг угтан 200 гаруй ахмад ажилчдаа угтан авч, сар шинийн тавгийн идээг бэлэглэлээ.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Талх Чихэр” ХК-ийн 1000 гаруй ажилчдын хүүхэд багачуудыг хүлээн авч, аав ээжийнхээ ажилтай танилцах, аав ээжтэйгээ хамт дурсамж бүтээх боломж бүрдүүлж ажиллаа.



- MNS ISO 9001 Чанарын менежментийн тогтолцооны стандартын давтан баталгаажуулалтын үнэлгээнд орж 3 жилээр гэрчилгээ авсан , MNS ISO 45001 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын стандартын магадлах аудит хийгдсэн.
- **“ТАЛХ ЧИХЭР” ХК ТОП-100 ААН-ЭЭР ДАХИН ШАЛГАРЛАА.**
- FSSC 22000 – Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтын иж бүрэн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, 2025 оны 06-р сард Олон улсын баталгаажуулалтын байгууллага “SGS” LLC –р хөндлөнгийн II-р шатны аудитын үнэлгээнд орж амжилттай баталгаажуулсан.





БҮЛЭГ 4

САНХҮҮГИЙН
ТАЙЛАН



14,6 ТЭРБУМ

Улсын нэгдсэн
төсвийн
орлогод




128,9 ТЭРБУМ

Нийт
борлуулалтын
орлого

2025 оны эхний хагас жилийн байдлаар **128,9** тэрбум төгрөгийн борлуулалт хийж, урьд оны энэ үеэс орлого **6,5** тэрбум төгрөгөөр буюу **5.8%-р** өссөн байна. Улсад орлогын татвар **1,6** тэрбум төгрөг төлсөн. Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод **14,6** тэрбумыг төвлөрүүлсэн байна.


ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО ХАРЬЦУУЛАЛТ

Борлуулалтын орлого




ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛАЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг




ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЗАРДЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

2024 он Талх Чихэр ХК-н зардал /сая,төгрөг/



■ Ерөнхий ба удирдлагын зардал ■ Үйл ажиллагааны зардал


2025 он Талх Чихэр ХК-н зардал / сая,төгрөг /



■ Ерөнхий ба удирдлагын зардал ■ Үйл ажиллагааны зардал


ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

2024 он Талх Чихэр ХК-н Эргэлтийн хөрөнгө бүтэц
/ сая,төгрөг /



- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны авлага
- Татвар, НДШ-н авлага
- Бариа материал
- Урьдчилж төлсөн зардал/ тооцоо


2025 он Талх Чихэр ХК-н Эргэлтийн хөрөнгө бүтэц
/ сая,төгрөг /




- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны авлага
- Татвар, НДШ-н авлага
- Бариа материал
- Урьдчилж төлсөн зардал/ тооцоо

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

2024 он Талх Чихэр ХК-н Өр төлбөрийн дүн
/ сая,төгрөг /




2025 он Талх Чихэр ХК-н Өр төлбөрийн дүн
/ сая,төгрөг /



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХАГАС ЖИЛИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Талх Чихэр ХК -н 2024 он болон 2025 он ашгийн харьцуулалт





*Анхаарал
хандуулсан та
бүхэнд баярлалаа*

ЭРҮҮЛ ХҮНС & ТАНЫ СОНГОЛТ